УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2017 оны 11 сарын 29 өдөр Дугаар А/229 Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар бүлгийн 2.4.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 2.9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хан-Уул дүүргийн 1, 2, 3 дугаар хороонд хэрэгжүүлж байгаа хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах туршилтын төслийн ажлын тоо хэмжээг нэмэгдүүлж, 3 байршилд хог хаягдал ангилан ялгах торон хогийн сав нэмж байршуулах ажлыг зохион байгуулахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т даалгасугай.

2. Хог хаягдал ангилан ялгах туршилтын төслийн нэмэлт ажилд шаардагдах зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

2. Дээрх ажилд шаардагдах 4,152,000 /Дөрвөн сая нэг зуун тавин хоёр мянга мянган/ төгрөгийг Хотын нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд 50-100м тутамд стандартын шаардлага хангасан хогийн сав байршуулах, Сандал, хогийн сав засварлах, арчлах, нөхөн сэргээх зардлын үлдэгдл эзс гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

D:\backup_old_pc\Work documents\doc 2017\Тушаал doc 2017.docx

1110301037

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2017 оны 11 дүгээр сарын 19 өдрийн
А/219 дүгээр тушаалын хавсралт

ХОГ ХАЯГДАЛ АНГИЛАН ЯЛГАХ ТУРШИЛТЫН
ТӨСЛИЙН НЭМЭЛТ АЖИЛД ШААРДАГДАХ
ЗАРДЛЫН ЗАДАРГАА

№	Ажлын нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ /₮/	Нийт үнэ /₮
1	Ангилан ялгах зориулалттай 3 тасалгаатай торон хогийн сав /4м х 2м х 1,5м/ хийж байршуулах	3	1,384,000	4,152,000